

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/76/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЦЭНД-АЮУШ ТАНАА

додд.ол.дс № УВА-додд/76/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




М.БАТСУУРЬ

0200200552

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>76,415,651.00</u>	<u>37,635,764.29</u>
33	АВЛАГА	166,439.00	11,827.29
335	Бусад авлага	166,439.00	11,827.29
3351	Байгууллагаас авах авлага	166,439.00	11,827.29
35	БАРАА МАТЕРИАЛ	76,249,212.00	37,623,937.00
354	Хангамжийн материал	66,449,212.00	27,823,937.00
35410	Бичиг хэргийн материал	781,760.00	00.00
35420	Аж ахуйн материал	45,272,201.00	21,053,937.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,760,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	5,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	18,630,251.00	6,770,000.00
35600	Мал амьтад	9,800,000.00	9,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>771,291,630.74</u>	<u>5,047,538,450.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	771,291,630.74	5,047,538,450.08
392	Биет хөрөнгө	734,559,230.74	5,010,806,050.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	478,428,003.55	4,784,889,508.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-80,433,297.38	-143,848,984.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,880,000.00	148,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-113,434,024.09	-108,190,499.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,026,246.00	94,237,502.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,560,922.13	-53,237,916.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,465,902.77	21,008,553.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,678,634.55	-13,044,022.75
39209	Зам, гүүрийн байгууламж	100,581,823.00	263,906,626.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-5,640,299.00	-51,885,711.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	245,826,913.30	204,912,761.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-137,902,480.73	-136,821,766.46
393	Биет бус хөрөнгө	36,732,400.00	36,732,400.00
39301	Програм хангамж	2,305,000.00	2,305,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,555,000.00	-1,555,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,982,400.00	35,982,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>847,707,281.74</u>	<u>5,085,174,214.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>555,291.20</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	555,291.20	00.00
413	Өглөг	555,291.20	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	410,139.20	00.00
4136	Бусад өглөг	145,152.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	145,152.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>847,151,990.54</u>	<u>5,085,174,214.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	847,151,990.54	5,085,174,214.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	278,498,129.17	278,498,129.17
51101	Өмч: - төрийн	278,498,129.17	278,498,129.17
512	Хуримтлагдсан үр дүн	370,418,831.11	4,608,947,305.16
51210	Өмнөх үеийн үр дүн	370,418,831.11	370,925,081.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,238,022,223.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198,235,030.26	197,728,780.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>847,707,281.74</u>	<u>5,085,174,214.37</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	589,215,929.00	4,921,916,570.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,328,520.00	4,430,431,592.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,328,520.00	4,430,431,592.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,328,520.00	4,430,431,592.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	53,328,520.00	4,430,431,592.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	535,887,409.00	491,484,978.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,308,000.00	419,970,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,308,000.00	419,970,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,579,409.00	71,514,778.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,579,409.00	60,515,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,389,778.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,624,438.17	683,894,346.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,510,069.17	625,949,346.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,787,051.66	579,109,922.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,149,707.37	246,769,224.00
210101	Үндсэн цалин	222,682,794.37	207,978,898.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,466,913.00	38,790,326.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,256,965.00	32,191,138.13
210201	Тэтгэврийн даатгал	22,060,044.00	22,488,012.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,595,291.00	2,483,384.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,072,873.00	1,936,470.00
210204	Ажилгүйдлийн даатгал	502,613.00	494,744.46
210205	Эрүүл мэндийн даатгал	5,026,144.00	4,788,526.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,241,110.00	32,662,632.00
210301	Гэрэл, цахилгаан	4,582,300.00	3,855,663.00
210302	Түлш, халаалт	24,658,810.00	28,806,969.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,145,367.00	82,015,989.00
210401	Бичиг хэрэг	3,804,250.00	3,396,849.00
210402	Тээвэр, шатахуун	26,294,896.00	23,278,385.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,025,121.00	2,197,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,021,100.00	53,143,215.00
2105	Нормативт зардал	50,000.00	3,513,400.00
210502	Хоол, хүнс	00.00	1,218,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	2,294,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,097,800.00	10,210,900.00
210602	Тавилга	00.00	30,000.00
210604	Урсгал засвар	10,097,800.00	10,180,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,322,600.00	3,121,000.00
210702	Дотоод албан томилолт	5,322,600.00	3,121,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,835,639.00	1,495,224.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,957,614.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	137,025.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	147,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	558,900.00
210807	Газрын төлбөр	174,400.00	174,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,687,863.29	167,130,415.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,090,750.00	25,345,643.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,097,113.29	141,664,772.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,723,017.51	46,839,423.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,398,900.00	32,066,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,453,900.00	23,978,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,945,000.00	1,775,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,324,117.51	14,773,123.38
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,114,369.00	57,945,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,114,369.00	57,945,000.00
223001	Бусад хөрөнгө	52,114,369.00	57,945,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,591,490.83	4,238,022,223.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,332,667.03	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,332,667.03	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,332,667.03	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,258,823.80	4,238,022,223.83

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	535,887,409.00	491,484,978.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	535,887,409.00	491,484,978.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,308,000.00	419,970,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,308,000.00	419,970,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,579,409.00	71,514,778.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,579,409.00	60,515,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,389,778.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	483,773,040.00	433,539,978.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,773,040.00	433,539,978.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,949,022.49	386,222,554.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,788,395.93	247,795,666.90
210101	Үндсэн цалин	216,551,671.00	208,977,646.90
210105	Гэрээт ажлын хөлс	40,236,724.93	38,818,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,376,838.56	31,714,313.72
210201	Тэтгэврийн даатгал	22,285,129.42	22,093,871.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,522,902.04	2,268,778.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,018,741.82	2,103,703.43
210204	Ажилгүйдлийн даатгал	504,160.22	524,962.74
210205	Эрүүл мэндийн даатгал	5,045,905.06	4,722,997.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,230,610.00	32,662,632.00
210301	Гэрэл, цахилгаан	4,582,300.00	3,855,663.00
210302	Түлш, халаалт	24,648,310.00	28,806,969.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,949,921.00	23,984,075.00
210401	Бичиг хэрэг	2,880,000.00	2,814,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,354,071.00	14,141,485.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,090,000.00	2,197,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,900.00	833,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,625,950.00	3,997,250.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	1,225,200.00
210502	Хоол, хүнс	00.00	975,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	249,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,110,443.00	3,265,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,270,000.00	00.00
210602	Тавилга	660,000.00	1,980,000.00
210604	Урсгал засвар	48,180,443.00	1,285,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,322,600.00	3,121,000.00
210702	Дотоод албан томилолт	5,322,600.00	3,121,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,995,639.00	1,495,224.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,957,614.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	137,025.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	147,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	558,900.00
210807	Газрын төлбөр	174,400.00	174,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,674,575.00	40,959,043.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,174,575.00	40,839,043.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,824,017.51	47,317,423.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,499,900.00	32,544,300.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,453,900.00	23,978,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,046,000.00	2,253,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,324,117.51	14,773,123.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,114,369.00	57,945,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,114,369.00	57,945,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,114,369.00	57,945,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,114,369.00	57,945,000.00
223001	Бусад хөрөнгө	52,114,369.00	57,945,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-52,114,369.00	-57,945,000.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	262,342,129.17	193,222,333.26	241,751,630.06	697,316,092.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,342,129.17	193,222,333.26	241,751,630.06	697,316,092.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,258,823.80	35,258,823.80
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	278,498,129.17	198,235,030.26	370,418,831.11	847,151,990.54
D01	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	278,498,129.17	198,235,030.26	370,418,831.11	847,151,990.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	506,250.22	506,250.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	278,498,129.17	198,235,030.26	370,925,081.33	847,658,240.76

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-506,250.22	00.00	-506,250.22
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,282,410,709.79	4,282,410,709.79
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	278,498,129.17	197,728,780.04	4,653,335,791.12	5,129,562,700.33

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,970,200.00	406,982,676.62	12,987,523.38	96.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,970,200.00	406,982,676.62	12,987,523.38	96.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,845,900.00	375,858,376.62	12,987,523.38	96.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,048,000.00	247,795,666.90	9,252,333.10	96.40
210101	Үндсэн цалин	216,558,700.00	208,977,646.90	7,581,053.10	96.50
210105	Гэрээт ажлын хөлс	40,489,300.00	38,818,020.00	1,671,280.00	95.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,701,500.00	31,714,313.72	2,987,186.28	91.39
210201	Тэтгэврийн даатгал	24,419,600.00	22,093,871.16	2,325,728.84	90.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,570,500.00	2,268,778.59	301,721.41	88.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,056,400.00	2,103,703.43	-47,303.43	102.30
210204	Ажилгүйдлийн даатгал	514,100.00	524,962.74	-10,862.74	102.11
210205	Эрүүл мэндийн даатгал	5,140,900.00	4,722,997.80	417,902.20	91.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,710,600.00	32,152,632.00	-442,032.00	101.39
210301	Гэрэл, цахилгаан	3,082,300.00	3,855,663.00	-773,363.00	125.09
210302	Түлш, халаалт	28,628,300.00	28,296,969.00	331,331.00	98.84
2104	Хангамж, бараа материалын зардал	17,924,100.00	17,409,240.00	514,860.00	97.13
210401	Бичиг хэрэг	2,398,800.00	2,398,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	11,567,500.00	11,567,450.00	50.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,449,300.00	1,935,540.00	513,760.00	79.02

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,000.00	833,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	675,500.00	674,450.00	1,050.00	99.84
2105	Нормативт зардал	249,900.00	249,900.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	249,900.00	249,900.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,285,400.00	1,285,400.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,285,400.00	1,285,400.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,469,600.00	3,121,000.00	348,600.00	89.95
210702	Дотоод албан томилолт	3,469,600.00	3,121,000.00	348,600.00	89.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,525,300.00	1,495,224.00	30,076.00	98.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	250,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	288,000.00	115,200.00	71.43
210803	Даатгалын үйлчилгээ	183,700.00	54,450.00	129,250.00	29.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	147,474.00	16,126.00	90.14
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	22,000.00	66,000.00	25.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	262,400.00	558,900.00	-296,500.00	213.00
210807	Газрын төлбөр	174,400.00	174,400.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40931500.00	40635000.00	296,500.00	99.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,515,000.00	40,515,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	120,000.00	296,500.00	28.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31124300.00	31124300.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,124,300.00	31,124,300.00	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	6,313,300.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,978,000.00	23,978,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	833,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	419,970,200.00	419,970,200.00	0.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	419,970,200.00	419,970,200.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	419,970,200.00	419,970,200.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00		
620001	Удирдах ажилтан	07.00	07.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00		
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00		
620004	Гэрээт ажилтан	06.00	06.00		

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		11,784,178.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		11,784,178.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,364,178.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		510,000.00
210302	Түлш, халаалт		510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,574,835.00
210401	Бичиг хэрэг		416,000.00
210402	Тээвэр, шатахуун		2,574,035.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		262,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,322,800.00
2105	Нормативт зардал		975,300.00
210502	Хоол, хүнс		975,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,980,000.00
210602	Тавилга		1,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	324,043.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		324,043.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,420,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,420,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-57,945,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		-57,945,000.00
223001	Бусад хөрөнгө		-57,945,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	69,729,178.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		69,729,178.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		6,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		60,515,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,604,178.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 2/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,526.2 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 683,894.3 мянган төгрөгийн 1 хувь буюу 6,838.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,471.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 801,174.6 мянган төгрөг буюу 5.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	166.4	11.8	-154.6

Бараа материал	76,249.2	37,623.9	-38,625.2
Үндсэн хөрөнгө	771,291.6	763,538.9	-7,752.7
Нийт хөрөнгө	847,707.3	801,174.6	-46,532.7
Өр төлбөр	555.3	0.0	-555.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	847,151.9	801,174.6	-45,977.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	847,707.3	801,174.6	46,532.7

Авлага дансны үлдэгдэл 11.8 мянган төгрөгөөр болж 154.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37,623.9 мянган төгрөг болж 38,625.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн данснаас материал зарцуулсантай холбоотой үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 801,174.6 мянган төгрөг болж 7,752.7 мянган төгрөгөөр буурсан нь Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 801,174.6 мянган төгрөг болж 45,977.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 48,701.1 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 131,269.9 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 485,563.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 65,593.0 мянган төгрөгөөр бууруулж 419,970.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 419,970.2 мянган төгрөгийг төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 419,970.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 406,982.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 406,982.6 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 69,729.2 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

Гүйцэтгэлийг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Хяргас сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн тул тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, байршуулах хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Хяргас сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар хандивын орлогыг төрийн сангийн хяналгүйгээр зарцуулсан албан шаардлага өгсөн байна. Дээрх албан шаардлагын биелэлтийг Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 2/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материал дансны мал амьтад данс, Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар эдгээр асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,314,999.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,283,999.5 мянган төгрөгийн хөв цөөрмийг данс бүртгэлд тусгуулж, 31,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хасаж залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 544 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/159 дугаар тогтоолыг тус тус зөрчин Хяргас сумын ЗДТГ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4,283,999.5 мянган төгрөгийн Хөв цөөрмийг данс бүртгэлд тусгаагүй байсныг данс бүртгэлд тусгуулан залруулга хийлгэв.
2. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/26 тоот тогтоолоор Хяргас сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 31,000.0 мянган төгрөгийн автомашиныг актлах шийдвэр гарсныг зөрчин данс бүртгэлээс хасаагүй байсныг залруулсан.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хяргас сумын Засаг даргын тамгын газрын	2	4,314,999.5	2	4,314,999.5						
	ДҮН	2	4,314,999.5	2	4,314,999.5						

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр